



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/540

Ховд

Хөрөнгө гаргаж, буцаан төвлөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 47 дүгээр зүйлийн 47.1.1 дэхь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 86 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ардын авъяастнууд, мэргэжлийн урлагийн байгууллагуудын санаачлага, Дэлхийн хөөмийн холбооноос хөөмийг, дэлхийн гиннесийн амжилтанд бүртгүүлэх уриалгыг дэмжиж Гиннесийн рекордыг бүртгэх газраас сорилтод оролцох эрх авах зардалд 82,1 сая төгрөг /Наян хоёр сая нэг зуун мянган/-ийг хавсралтаар баталж БНХАУ-аас аймагт олгосон хандивын орлогоос урьдчилан олгож 2019 оны 11 дүгээр сарын 01-ний дотор буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

2. Гиннесийн рекордыг бүртгэх газраас сорилтод оролцох эрх авах зардал болох 82,1 сая төгрөг /Наян хоёр сая нэг зуун мянган/-ийн санхүүжилт хийх болон хугацаандаа буцаан төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

D/Zax-A/540-Da

00 02730

Аймгийн Засаг даргын 2019 оны  
08 дугаар сарын 14-ний өдрийн  
А/540 дугаар захирамжийн хавсралт



ХӨӨМИЙГ ДЭЛХИЙН ГЕННЕСИЙН АМЖИЛТАНД  
БҮРТГҮҮЛЭХЭД ОЛГОЖ ЭРГЭН ТӨВЛӨРҮҮЛЭХ  
ЗАРДАЛ

д/д	Үзүүлэлт	Төлөх дүн	
		Валютаар	Төгрөгөөр
1	Гиннесийн рекордыг бүртгэх газраас сорилтод оролцох эрх авах зардал /Guinness Word Records Нэхэмжлэлийн дугаар RMTСNUK0003488 гэрээний дугаар 016770/	24800.00 евро	82100000.00